

**ГХБХБГ-ЫН 5 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.05.04.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан 2018 оны 04-р сарын 27-30-ний өдрүүдэд ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан дараах арга хэмжээнд газрын дарга К.Болат болон мэргэжилтэн Х.Өмиржан нар оролцов.</p> <p>Үүнд: 1. “Газар өмчлөл -15 жил” үндэсний форм; 2. Шилжин явах цомын 2018 оны улсын аварга шалгаруулах спортын тэмцээн; 3. Хүндэтгэлийн арга хэмжээ.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Алтай сум: Шинээр газар эзэмшүүлэх 2, газрын маргаантай 3 өргөдлийн хүсэлтийг тус тус хүлээн авч бүртгэв.</p> <p>2 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 програмын цахимд архивласан. Мөн бүх багийн өвөлжөө, хаваржааны байршлыг тогтов.</p> <p>Алтанцөгц сум: 10 иргэнийг ЛМ програмд оруулж холболт хийв.</p> <ul style="list-style-type: none"> · Газар эзэмшүүлэх захирамж төлөвлөн Засаг даргад танилцуулж батлуулав. · Газар өмчлөлийн 45 хоногийн аянтай холбоотой арга хэмжээний ажлын зохион байгуулж, аймгийн ГХБХБГазарт тайлангаа хүргүүлэв. <p>Баяннуур сум: Аж ахуйн нэгж, ард иргэдээс ирсэн 3 өргөдөл, санал хүсэлт, хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэв.</p> <p>Ажлын төлөвлөгөөний дагуу өдөр бүр дотоод ажиллаа хийж</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

гүйцэтгэж байна. Хадлангийн талбайн 3 иргэний эрх шилжүүлэв. Аймгийн онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгаас урьдчилан сэргийлэх талаар сургалт семинарт оролцож бэлтгэл ажлаа хийж кадастрын зураг гаргаж бэлэн болгож байна.

Газрын төлбөрийн төлөвлөгөөг гаргасан графикийн дагуу 5-р сард 1 хүнд 48000 мянган төгрөгийн төлбөр оруулав.

Бугат сум: 7 иргэний үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж өгөв. Сумын төвийн 8 иргэний газрын байршлыг тодруулж ирсэн. 10 иргэний нэгж талбарын хувийн хэрэг бүрдүүлэв. 3 иргэнд Хадлан ашиглах, 3 иргэнд газар өмчлөх захирамжийг тус тус гаргуулав.

Толбо сум: Шинээр газар эзэмшигч иргэдэд гэрчилгээ олгон улсын бүртгэлд тусган үйлчилж, хувийн хэрэг шинээр нээж ажилласан болно. Мөн 4 өргөдөл хүлээн авч гомдлыг тухайн үед эзэнтэй хариу өгч ажиллав.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР